



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
**ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/ЧО

Улаанбаатар хот

Төвийн захирлыг сонгон шалгаруулах  
үйл ажиллагааны удирдамж, комиссын гишүүдийг  
батлах тухай

ШУТИС-ийн Ректорын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Сургалт, судалгааны төв байгуулах тухай” А/193 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийн захирлын сонгон шалгаруулалтын удирдамжийг Хавсралт 1-ээр, захирлын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн урьдчилсан шалгаруулалтын комиссын гишүүдийг Хавсралт 2-оор тус тус баталсугай. (Хавсралт 4 хуудас)
2. Батлагдсан удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг урьдчилсан шалгаруулалтын комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Бя.БАТ-ЭРДЭНЭ

ЭХИС-ийн захирлын 2025 оны 06-р сарын  
13-ны өдрийн А/40 тоот тушаалын хавсралт 1



## **“Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийн захирлын сонгон шалгаруулалтын удирдамж**

### **Нэг. Ерөнхий үндэслэл**

Энэхүү удирдамж нь “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийн захирлын албан тушаалд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах зорилго, шалгаруулалтын зарчим, шалгуур үзүүлэлт, зохион байгуулалт, хэрэгжүүлэх үйл явц, үнэлгээний аргачлалыг тодорхойлно.

### **Хоёр. Сонгон шалгаруулалтын зорилго**

Тус төвийг шинжлэх ухаан, технологи, судалгаа хөгжүүлэлт, инновац, олон улсын хамтын ажиллагаа, салбарын манлайллын чиглэлээр удирдан зохион байгуулах чадвартай, өндөр ёс зүй, мэдлэг, туршлага бүхий захирлыг сонгон шалгаруулахад оршино.

### **Гурав. Захирлын үндсэн чиг үүрэг**

- Төвийн хөгжлийн бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх
- Судалгаа, туршилт, инновацын төслүүдийг удирдан зохион байгуулах
- Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг татах, гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Санхүү, хүний нөөц, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах
- Сэргээгдэх эрчим хүчний салбарын шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийн хөгжлийг дэмжих, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх
- Судалгааны үр дүнг бодит үйлдвэрлэлд нутагшуулах, хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг удирдах

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага**

#### **1. Ерөнхий шаардлага:**

- Монгол Улсын иргэн байх
- Эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх чадвартай
- Ял шийтгэлгүй байх, төрийн албанд ажиллах эрх хязгаарлагдаагүй байх

#### **2. Боловсрол, мэргэжлийн шаардлага:**

- Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, инженер, байгаль орчин, менежмент болон түүнтэй адил төстэй мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Судалгаа, хөгжүүлэлт, төслийн удирдлага, байгууллагын удирдлагын чиглэлээр 5-аас дээш жилийн ажлын туршлагатай байх
- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх



### 3. Ур чадварын шаардлага:

- Манлайлах чадвар, багаар ажиллах болон тэнхим хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах ур чадвартай байх
- Стратеги төлөвлөлт, шийдвэр гаргалт, асуудал шийдвэрлэх чадвартай байх
- Санхүүгийн зохистой менежмент хийх чадвартай байх
- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр төсөл, хөтөлбөрт оролцож байсан туршлагатай байх
- Судалгаа шинжилгээний ажлын туршлагатай байх нь давуу тал болно

### Тав. Бүрдүүлэх материал

- Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт
- Анкет, товч намтар (CV)
- Боловсрол, мэргэжлийн диплом, гэрчилгээ, батламжийн хуулбар
- Ажлын туршлага, гүйцэтгэсэн төслүүдийн тайлан, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Судалгаа хөгжүүлэлтийн болон бизнесийн 3-5 жилийн хөгжлийн бодлогын санал, төсөөлөл (2-3 хуудас)

*Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.*

*Нэр дэвшигч нь төвийн түшиглэн ажиллах Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлах "Нар болон салхины эрчим хүч хуримтлуулах төв"-ийн техникийн бичиг, баримттай ШУТИС-ийн хичээлийн 2 дугаар байрны 619 тоот өрөөнд ирж танилцах боломжтой.*

### Зургаа. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шалгаруулах, шийдвэр гаргалт

1. Материал хүлээн авах: Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн бүрдүүлсэн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэн, ШУТИС-ийн хичээлийн 2 дугаар байрны 619 тоот өрөөнд (Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн захирлын туслах)-д өөрийн биеэр хүлээлгэн өгнө. Хүлээн авах хугацаа: 2025 оны 06-р сарын 16-ны өдрийн 09:00 цагаас 06-р сарын 20-ны өдрийн 12:00 цаг хүртэл. (Ажлын өдрүүдэд), Холбоо барих утас: 11-323579 (Ажлын цагаар).
2. Захирлын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн урьдчилсан шалгаруулалтын комисс нэр дэвшигчийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл, 4-р хэсэгт заасан оролцогчид тавигдах шаардлагуудыг хангасан эсэхийг нягтална.
3. Ярилцлага, илтгэл: Захирлын зөвлөлийн хуралд нэр дэвшигч бүр илтгэл тавьж хийх ажлын төлөвлөгөөгөө танилцуулна. Хурлын төгсгөлд нэр дэвшигч бүрд өгөх үнэлгээг 7-р хэсэгт заасан үнэлгээний аргачлалаар нууц санал хураалтаар авна.



4. Нэр дэвшигч бүрээр дундаж оноог гаргана.
5. Шалгаруулалтын эцсийн дүнг гарган танилцуулна. Хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг сонгон нэрийг ШУТИС-н Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор, Инновац, бизнес түншлэлийн албанд хүргүүлнэ.

**Долоо. Үнэлгээний аргачлал**

| Үзүүлэлт                               | Оноо |
|--|------|
| Боловсролын зэрэг, мэргэжлийн туршлага | 30   |
| Манлайлал, ур чадвар                   | 20   |
| Хөгжлийн бодлогын санал                | 20   |
| Судалгаа шинжилгээний туршлага         | 10   |
| Асуулт, хариултын үр дүн               | 10   |
| Гадаад хэлний мэдлэг                   | 10   |
| Нийт                                   | 100  |

**Найм. Бусад**

- Бүрдүүлсэн материалд хуурамч мэдээлэл илэрвэл нэр дэвшигчийг шууд хасна.
- Сонгон шалгаруулалт ил тод, шударга, тэгш боломжийн зарчмаар явагдана.
- Захирлын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрээр батална.

ЭХИС-ийн захирлын 2025 оны 06-р сарын  
13-ны өдрийн А/Н/О тоот тушаалын хэвсралт 2



**“Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийн  
захирлыг сонгон шалгаруулах урьдчилсан комисс**

Урьдчилсан комиссын бүрэлдэхүүн:

Дарга: М.Ганхүлэг, Шинэ, сэргээгдэх эрчим хүчний тэнхимийн  
эрхлэгч, Доктор

Гишүүд: Ш.Гантөмөр, Цахилгааны инженерийн тэнхимийн эрхлэгч,  
Доктор, дэд профессор

П.Бямбацогт, Дулаан хангамж, автоматжуулалтын  
тэнхимийн эрхлэгч, Доктор